



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/А

Мандалговь

Ажилтан, албан хаагчдад зориулан
"Мэргэжилтнүүдийн ажлын уялдаа холбоо,
харилцаа, хандлага, ёс зүйг төлөвшүүлэх нь"
сэдэвт сургалт зохион байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.9, Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны сургалтын төлөвлөгөөний 1.1.1, Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын ажилтан, албан хаагчдад зориулсан "Мэргэжилтнүүдийн ажлын уялдаа холбоо, харилцаа, хандлага ёс зүйг сайжруулах нь" сэдэвт сургалтыг 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулсугай.

2. Сургалтын хөтөлбөрийг 1 дүгээр, шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалтын үйл ажиллагаанд шаардагдах 657,200 (Зургаан зуун тавин долоон мянга хоёр зуу) төгрөгийг Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (С.Чинбаат)-д зөвшөөрсүгэй.

4. Сургалтад идэвхитэй хамрагдаж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

5. Сургалтыг чанартай зохион байгуулан, үр дүнг 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Захиргаа, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн (Р.Мөнхбат)-д даалгасугай.

ДАРГА

Ц.ГАНЗОРИГ

• 482201035

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2022 оны 04 дугаар сарын 13-ны өдрийн
100 дугаар тушаалын 01 дүгээр хавсралт

БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДАД
ЗОРИУЛСАН "МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН АЖЛЫН УЯЛДАА ХОЛБОО, ХАРИЛЦАА,
ХАНДЛАГА ЁС ЗҮЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХ НЬ" СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Зорилго: Албан хаагчдын мэдлэг чадвар, ажиллах идэвхи санаачлагыг
нэмэгдүүлэх, ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулахад оршино.

Хугацаа	Хөтөлбөрийн дараалал	Хариуцах эзэн
2022 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР		
08:50-09:00	Сургалтын нээлт	Газрын дарга Ц.Ганзориг
09:00-11:00	Хүүхдийн талаар баримтлах үзэл хандлага, түүний хэрэгжилтийг хангах арга зүй	Доктор, дэд профессор Х.Баавгай
11:00-11:10	Цайны завсарлага	
11:10-13:10	Мэргэжилтнүүдийн ажлын уялдаа, холбоог хангах, багаар ажиллах боломж	Доктор, дэд профессор Х.Баавгай
13:10-15:10	Албан хаагчдын хоорондын харилцаа, хандлагаыг сайжруулах арга зам	Доктор, дэд профессор Х.Баавгай
15:10-15:20	Цайны завсарлага	
15:20-17:20	Төрийн албан хаагчийн ёс зүй, анхаарах асуудлууд	Доктор, дэд профессор Х.Баавгай
17:20-17:55	Дадлага ажил	Доктор, дэд профессор Х.Баавгай

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2022 оны 09 дугаар сарын 01 ны өдрийн
1169 дугаар тушаалын 02 дүгээр хавсралт

БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДАД ЗОРИУЛСАН
"МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН АЖЛЫН УЯЛДАА ХОЛБОО, ХАРИЛЦАА, ХАНДЛАГА ЁС
ЗҮЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХ НЬ" СУРГАЛТАД ШААРДАГДАХ ТӨСВИЙН ТООЦООЛОЛ

№	Материалын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Дүн /төгрөг
1	Сургалтын хөлс	8	40,000	320,000
2	Кофе	4	14000	56,000
3	Сэндвич	20	4500	90,000
4	Печень	20	1500	30,000
5	Бичгийн цаас	5	19,000	95,000
6	Бал	20	1,500	30,000
7	Тэмдэглэлийн дэвтэр	20	3,750	75,000
Нийт				657,200

-oOo-

.